



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 0022/УЗТ/01

Сайхан сум

Шүүхэд эрүү, зөрчлийн хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах болон Эрүү, Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн шүүгчдийн 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч шүүгч Г.Сарантуяа даргалж, шүүгч А.Нарантуяа, шүүгч Г.Дэлгэрсайхан шүүгч Г.Алгирмаа, нарийн бичгийн дарга О.Номин нарыг байлцуулан Нийт шүүгчдийн анхдугаар чуулганаар батлагдсан "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам"-д /цаашид нийтлэг журам гэх/ нийцүүлэн 2022 онд эрүүгийн хэрэг, зөрчлийн хэргийн шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгчдийг сугалаагаар томилох, хэрэг хуваарилах нарийвчилсан журмыг батлах асуудлыг хэлэлцэв.

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 19.2 дугаар зүйлийн 19.2.1, 19.2.2, 19.2.5 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 6, Нийтлэг журмын 1.1 -д заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Хэрэг хуваарилах шүүгчдийн дарааллыг сугалаагаар томилох

1.1.Хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүний дарааллыг урьдчилан мэдэх боломжгүй, хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулан шуурхай байдлаар сугалаа сугалсны дагуу дор дурдсанаар тогтоосугай.

а.Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

1.Шүүгч А.Нарантуяа

2.Ерөнхий шүүгч Г.Сарантуяа

3.Шүүгч Г.Дэлгэрсайхан

4.Шүүгч Г.Алгирмаа гэсэн дарааллаар байршуулж тойрог үүсгэсүгэй.

1.2.Шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд байршуулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэн Х.Батболдод даалгасугай.

2.Шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилох

432100800003

4.1. Шүүх хуралдааныг даргалах болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллын дагуу Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс хуваарилсныг Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-д зааснаар Ерөнхий шүүгч захирамж гарган албажуулсугай.

4.2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн 2021/ШЗТ/04 тоот Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.3. Энэ тогтоолыг 2022 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ШҮҮГЧИД



Г. САРАНТУЯА

А. НАРАНТУЯА

Т. ДЭЛГЭРСАЙХАН

Г. АЛГИРМАА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 01

Сайхан сум

Шүүхэд иргэний хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах болон Иргэний хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам батлах

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн шүүгчдийн 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч шүүгч Г.Сарантуяа даргалж, шүүгч А.Нарантуяа, шүүгч Г.Дэлгэрсайхан шүүгч Г.Алгирмаа, нарийн бичгийн дарга О.Номин нарыг байлцуулан 2022 онд Иргэний хэргийн шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгчдийг сугалаагаар томилох, хэрэг хуваарилах нарийвчилсан журмыг батлах асуудлыг хэлэлцэв.

Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 19 дугаар зүйлийн 19.2.1, 19.2.2, 19.2.5, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.6-д заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Хэрэг хуваарилах шүүгчдийн дарааллыг сугалаагаар тогтоох

1.1 Хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүний дарааллыг урьдчилан мэдэх боломжгүй, хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулан шуурхай байдлаар сугалаа сугалсны дагуу дор дурдсанаар тогтоосугай.

Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

1.Шүүгч А.Нарантуяа

2.Ерөнхий шүүгч Г.Сарантуяа

3.Шүүгч Г.Дэлгэрсайхан

4.Шүүгч Г.Алгирмаа гэсэн дарааллаар байршуулж тойрог үүсгэсүгэй

1.2.Шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "Иргэн-2014" нэгдсэн системд байршуулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэн С.Батболдод даалгасугай.

2. Шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилох

432100800006

2.1. Хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томилох дарааллыг дор дурдсанаар тогтоосугай.

Хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

1. Шүүгч А. Нарантуяа
2. Ерөнхий шүүгч Г. Сарантуяа
3. Шүүгч Г. Дэлгэрсайхан
4. Шүүгч Г. Алгирмаа

2.2. Бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралд оролцож чадахгүй тохиолдолд өөр шүүгч томилохоор тогтоосугай.

2.3. Шүүх бүрэлдэхүүнээр хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг илтгэгч шүүгч даргалахаар тогтоосугай.

2.4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг томилж оролцуулсугай.

2.5. Өөр шүүхийн хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг 2.1-д заасныг баримталж томилсугай.

2.6. Тогтоолын 2.5 дугаарт заасны дагуу томилогдсон шүүгч тухайн шүүх хуралдаанд оролцож чадахгүй тохиолдолд /10-дээш хоногоор өвчтэй, чөлөөтэй, шүүх хурал давхцаж байгаа болон бусад шалтгаанаар/ тогтоолын 2.1-д заасны дагуу шүүгчийг томилсугай.

2.7. Ээлжийн амралтаа авсан шүүгч орон нутагтаа амарч байгаа үед шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр иргэний хэргийн шүүх бүрэлдэхүүнд томилж оролцуулсугай.

2.8. Ээлжийн амралттай шүүгч шүүх бүрэлдэхүүнд ирж оролцсон тохиолдолд нөхөн амруулахыг тус шүүхийн Тамгын газарт даалгасугай.

2.9. Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн энэ тогтоолд зааснаас өөр байдлаар өөрчлөгдөхгүй болохыг дурдсугай.

2.10. Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөх үндэслэл болохгүйг дурдсугай.

2.11. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тухайн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд программд өөрчилсөн үндэслэл, шийдвэрийн талаар шаардагдах өгөгдлүүдийг оруулах бөгөөд энэ талаарх баримтын хувийг мэдээлэл технологийн мэргэжилтэнд хадгалуулж жил бүр архивад шилжүүлж байсугай.

2.12. Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хуулбарлан хадгалж хяналт тавихыг Шүүхийн Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

3. Хэрэг хуваарилах журам батлах

3.1. Иргэний хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчид хуваарилах журмыг хавсралтаар тус тус баталсугай.

4. Ерөнхий шүүгчийн албажуулах ажиллагаа

4.1. Шүүх хуралдааныг даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллын дагуу Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "Иргэн 2014" нэгдсэн системээс хуваарилсныг Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-д зааснаар Ерөнхий шүүгч захирамж гарган албажуулсугай.

4.2 Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 25 тоот шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.3 Энэ тогтоолыг 2022 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Г.САРАНТУЯА

ШҮҮГЧИД

А.НАРАНТУЯА

Г.ДЭЛГЭРСАЙХАН

Б.АЛГИРМАА